



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/152

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
боловсролыг дэмжих зарим арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14.2.2, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 55, 63 дугаар сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан хаагч нарт үүрэг болгосугай:

1.1. Нийслэлийн ерөнхий боловсролын 55, 63 дугаар сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир), Нийслэлийн боловсролын газар (Б.Амартүвшин) нарт;

1.2. Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, туршин, батлуулахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (Х.Отгонбаатар), Ерөнхий боловсролын бодлогын газар (Л.Ганбат) нарт;

1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ахиц өөрчлөлтийн үнэлгээг хөгжлийн хэрэгцээнд тохируулан боловсруулж, хэрэгжүүлэхийг Боловсролын үнэлгээний төв (Э.Цэрэнцоодол)-д, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын мэдээллийн системд бүртгэх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын мэдээллийн технологийн төв, Цахим боловсролын бодлого, өгөгдлийн шинжилгээний газарт;

1.4. Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сургуулиудын сургалтын орчныг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, хүний нөөцийг чадавхжуулж, арга зүйгээр ханган ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т;

1.5. Нийслэлийн ерөнхий боловсролын 55, 63 дугаар сургуулийг түшиц сургуулиар сонгон, үйл ажиллагааг эхлүүлэх арга хэмжээ авахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (Х.Отгонбаатар)-д, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусган олгохыг Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газарт;

1426010459

1.6. Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сургуульд мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хэлтэст;

1.7. Сургуулийн дүрмийг шинэчлэн баталж, туршилтын хөтөлбөр, төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийг нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургуулийн захирал (Г.Ганбилэг), нийслэлийн ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн захирал (Д.Эрдэнэбаатар) нарт.

2. Энэхүү тушаалын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан зардал болох 20,000,000 (хорин сая) төгрөгийг Боловсролын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Хөтөлбөр арга хэмжээний 2026 оны жагсаалт шинэчлэн батлах тухай" А/28 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Боловсролын сайдын 2026 оны хөтөлбөр арга хэмжээний жагсаалт"-ын 2.1.15-т заасан зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Ням-Очир)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, ажлын хэсгийг зохион байгуулалтаар ханган ажлын явцыг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (П.Оюунаа)-д үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсролын сайдын
2026 оны 06 дугаар сарын 22 ны өдрийн
А/Б/ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

П.Оюунаа

Боловсролын сайдын орон тооны зөвлөх

Гишүүд:

Х.Тамир

Боловсролын ерөнхий газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Б.Бадамжав

Боловсролын яамны газрын дарга

Л.Ганбат

Ж.Мягмар

Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга
Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга

Б.Амартүвшин

Нийслэлийн боловсролын газрын дарга

А.Мөнх-Оргил

Боловсролын яамны Ахлах шинжээч

Н.Мөнхсанчир

Боловсролын яамны Ахлах шинжээч

А.Цолмон

Боловсролын яамны Ахлах шинжээч

Ц.Чимэдлхам

Боловсролын яамны шинжээч

Д.Эрдэнэбат

Боловсролын яамны шинжээч

Х.Отгонбаатар

Э.Цэрэнцоодол

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал
Боловсролын үнэлгээний төвийн захирлын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Г.Ганбилэг

Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургуулийн
захирал

Ц.Эрдэнэбаатар

Нийслэлийн ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн
захирал

Ц.Дарьсүрэн

Сайдын орон тооны бус зөвлөх

Нарийн бичгийн
дарга:

Г.Саранхүү

Боловсролын яамны Ахлах шинжээч

Боловсролын сайдын
2026 оны 06 дугаар сарын 12 ны өдрийн
А/152 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Нийслэлийн ерөнхий боловсролын 55, 63 дугаар сургуулийг
хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх
чиг үүргийг хэрэгжүүлэхэд бэлтгэл ажлыг хангахтай холбоотой зардал

№	Зардлын нэр	Үнэ
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 55, 63 дугаар сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд бэлтгэл ажлыг хангахтай холбоотой зардал	20,000,000
	Нийт	20,000,000

---000---